МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 26 өдөр Дугаар А/464 Мөрөн сум

Газар эзэмших эрхийг дуусгавар
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.2, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1, 40.1.6, 40.3, 40.4, 41 дүгээр зүйлийн 41.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 79/А2260435/-НАГ/-2019/07/-НА дугаартай албан шаардлагын дагуу Мөрөн сумын 13 дугаар баг Зүүн Мөрөн орон сууцны хорооллын газарт "Нутгийн аваргууд сургууль" нь боловсролын байгууллагын зориулалтаар 2 га газрыг эзэмшиж, тус газраа гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй тул аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/206 шийдвэрийг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Дээрх захирамжийн дагуу Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийж, захирамжийг холбогдох этгээдэд танилцуулах ажлыг шуурхай зохион байгуулж, баримтыг бүрдүүлэн ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг эс зөвшөөрвөл захирамж гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

671 011793